

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлав.

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ ДЭРГЭДЭХ ЗАЛУУЧУУДЫН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. Зорилго

1.1 Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны дэргэдэх Залуучуудын хороо /цаашид хороо гэнэ/ нь үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний ардчиллыг хөгжүүлэх, залуучуудын хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгааг хангах талаар МҮЭ-ийн бодлогыг хэрэгжүүлэх, сургалт, компанит ажил зохион байгуулах, Эрчим хүч, геологи, уул уурхайн салбартай холбогдолтой хууль тогтоомж, конвенциудыг хэрэгжүүлэхэд залуучуудын хүч санаачлагыг өрнүүлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, үйлдвэрчний эвлэлийн залуу удирдагч нарыг бэлтгэх зорилго бүхий байгууллага мөн.

1.2 Энэхүү журмыг салбарын ҮЭ-ийн хороодын дэргэдэх Залуучуудын хэсэг мөрдөж ажиллана.

ХОЁР. Хорооны бүтэц, бүрэлдэхүүн

2.1 МЭХГУУ-н ҮЭ-ийн холбоо нь дэргэдээ Залуучуудын хороог, ҮЭ-ийн хороод нь Залуучуудын хэсгийг байгуулж ажиллана. Хороо, хэсгүүд нь 35 хүртлэх насны гишүүдтэй байна.

2.2 Залуучуудын төлөөллийн хурлыг 4 жил тутам хуралдуулж Тэргүүлэгчдийг сонгож батална. Залуучуудын хорооны Тэргүүлэгчид нь ҮЭ-ийн хороодын залуучуудын асуудал хариуцсан хэсгийн дарга нараас сонгогдоно. Хорооны Тэргүүлэгчид нь 9 гишүүнтэй байна.

2.3 Тэргүүлэгчдийн хурлаас хорооны даргыг сонгоно. Хорооны Тэргүүлэгчдийн 60-аас дээш хувийн саналаар даргыг огцруулах, дахин сонгох асуудлыг шийдвэрлэнэ.

2.4 Хорооны нарийн бичгийн даргын үүргийг салбарын ҮЭ-ийн холбооны ажлын албаны залуучуудын асуудал хариуцсан ажилтан гүйцэтгэнэ.

ГУРАВ. Хорооны Тэргүүлэгчдийн эрх, үүрэг

3.1 Товлосон хугацаанд хуралдаа хоцролгүй ирэх ба хурлаар хэлэлцэх асуудлаарх өөрийн санал, байр сууриа бичгээр товч тэмдэглэж хуралд ажил хэрэгч хандаж байх

3.2 Тодорхой асуудлаарх хариуцаж авсан ажил үүргээ чармайлт гарган хийж гүйцэтгэх ба ажлын шаардлагаар үүргээ гүйцэтгэхэд хүндрэл гарвал урьдчилан нарийн бичгийн даргадаа мэдэгдэж уг асуудлыг хугацаа алдалгүй шийдвэрлэж байх

3.3 Тэргүүлэгчийн нас 35-аас хэтэрсэн бөгөөд цаашид хороондоо ажиллах хүсэлтээ гаргавал дараагийн тэргүүлэгчийг ажил үүргээ бүрэн хариуцах хүртэл ажиллана.

3.4 Тайланг хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын талаар товч, тодорхой, тоо мэдээ бүхий тайланг бичгээр ирүүлэхээс гадна Тэргүүлэгчдийн хуралд танилцуулж, шаардлагатай тохиолдолд дэмжлэг авах

3.5 Тайлан, хийж гүйцэтгэсэн ажил үүргийнхээ үр дүнд ҮЭ-ийн гишүүний харьяаллынхаа дагуу урамшуулал авах хүсэлтээ гаргаж, Тэргүүлэгчдийн хурлын шийдвэр гаргуулж урамшууллаа тогтоосон хугацаандаа гаргуулж авах

ДӨРӨВ. Тэргүүлэгчийн ажил үүргээс түдгэлзэх,

Тэргүүлэгчээс татгалзах

4.1 Тэргүүлэгч 39 нас хүрсэн болон анхан шатны ҮЭ-ийн хорооны Залуучуудын хэсгийн даргын сонгуулиар ажлаа өгсөн бол хорооны Тэргүүлэгчдийн хурлын бүрэлдэхүүнээс хасагдах бөгөөд шинээр сонгогдсон Залуучуудын хэсгийн дарга Тэргүүлэгчдийн хурлын бүрэлдэхүүнд орно.

4.2 Тэргүүлэгч нь өндөр ёс зүйтэй, хариуцлага хүлээх чадвартай, харилцааны тодорхой ур чадвар эзэмшсэн байх бөгөөд энэ шаардлагыг биелүүлээгүй талаар Тэргүүлэгчдийн хурлаар авч хэлэлцээд гишүүдийн дийлэнх олонхи нь тухайн тэргүүлэгчийг тэргүүлэгчдийн хуралд байх эсэх талаар хэлэлцэж, шийдвэр гаргах

4.3 Тэргүүлэгч нь эрүүл мэндийн болон ажлын шаардлагын улмаас гишүүнийхээ үүрэгт ажлыг хийж гүйцэтгэх боломжгүй болбол энэ тухайгаа хороонд урьдчилан мэдэгдэж Залуучуудын хэсгийн даргын сонгуулиа явуулж Тэргүүлэгчийг сонгогдтол үүргээ гүйцэтгэх

ТАВ. Хорооны ажиллах журам

5.1 Тэргүүлэгчдийн хурлаас сонгогдсон дарга хорооны ажлыг удирдан явуулна. Хорооны дотоод ажлыг нарийн бичгийн дарга хариуцана.

5.2 Тэргүүлэгчид нь хороо хэсгүүдээс ирүүлсэн саналуудыг нэгтгэн, дара оны ажлын төлөвлөгөөг 11.20-ны дотор гарган батлуулна.

5.3 Тэргүүлэгчид нь хийгдсэн ажлын тайлангаа тэргүүлэгчдийн хуралд тайлагнана.

5.4 Хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд хурлыг зарлан хуралдуулж болно. /Ажлын шаардлагаар хугацаа алдалгүй интернет хурал хийж асуудлыг тухай бүр нь шийдвэрлэж байна. /

5.5 Залуучуудын хорооноос явуулах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг салбарын ҮЭ-ийн холбооны үйл ажиллагааны төсөвт 5-аас доошгүй хувиар тусгана.

5.6 Хороо нь хуралдаж хэлэлцсэн асуудлаараа санал, дүгнэлт, зөвлөмж гарган ҮЭ-ийн холбооны Удирдах зөвлөл, Гүйцэтгэх хорооны хуралдаан, Бага хуралд оруулна.

5.7 Хороо нь эрхэлсэн ажлын чиглэлээр олон улсын байгууллага, МҮЭ-ийн холбоо, аж ахуйн нэгж, ҮЭ-ийн хороодтой хамтран ажиллаж залуучуудын эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй иргэд байгууллага, эвсэл хөдөлгөөнийг дэмжинэ.

5.8 Хороо нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга тэмдэгтэй байна.

Зургаа. Хорооны бүрэн эрх

6.1 Залуучуудын хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, тэднийг үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаанд татан оролцуулах

6.2 Холбооны Тэргүүлэгчийн хуралд эрхэлсэн ажлын чиглэлээр асуудал тавьж, шийдвэрлүүлэх

6.3 Холбооны ажлын төлөвлөгөөнд эрхэлсэн ажлын талаар аж ахуйн нэгжийн ҮЭ-ийн хороодтой хамтарсан үйл ажиллагаа явуулах, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулж авах

6.4 Залуучууд эрх ашиг, сонирхолыг хөндсөн асуудлаар залуучууд, үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах

6.5 Салбарын хэмжээнд залуучуудыг бүрэн төлөөлөх ба шаардлагатай тохиолдолд Залуучуудын хэсгүүдээс аливаа тоо мэдээ, судалгааг гаргуулж авах

Долоо. Хорооны үүрэг

7.1 Залуучуудын талаархи МҮЭ-ийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, сургалт, кампанит ажлыг зохион байгуулах, санал боловсруулах

7.2 Залуучуудын хөдөлмөр, нийгмийн баталгааг хангах, тэдний эрх ашиг сонирхолыг хөндсөн асуудлаар МҮЭ-ийн холбоо, салбарын ҮЭ-ийн холбоонд санал хүсэлт тавих

7.3 Үйлдвэрчний эвлэлийн удирдах ажилд залуучуудыг бэлтгэх, тэдний нэрийг дэвшүүлэх, бусад залуучуудын байгууллагатай хамтран ажиллах

7.4 Үйлдвэрчний эвлэлийн зорилго, үйл ажиллагааны талаар залуучуудад мэдлэг олгох, мэдээлэл өгөх

7.5 Залуучуудад зориулсан урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах

7.6 Салбарын залуучуудын чуулга уулзалтыг 2 жил тутам өндөр хэмжээнд зохион байгуулж залуучуудын хэсгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах

---oOO---